



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/84/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас: 51-261885 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn
Ахлах аудитор С.Отгонхорлоо
Утас: 51-261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
"Ворлдвайд файнэнс аудит" ХХК-ийн захирал С.Оюунгэрэл
Утас: 99032466 Цахим хаяг: oyungerels.sag@gmail.com

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө.....	11
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
3.5.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл.....	12
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	20
7. Албан шаардлага.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АУЭХС	Алтай-Улиастайн эрчим хүчний систем
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх станц
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тосгоуу 3,
Мингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/680

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын "Эрчим хүчний салбарын төрийн өмчит зарим компанийн талаар авах арга хэмжээний тухай" 2025 оны 30 дугаар тогтоолд үндэслэн гарсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 604, 605 дугаар тогтоолын дагуу "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК, "Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 599 нэр төрлийн 55,778.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж авсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын эрчим хүчний салбар нь нэг худалдан авагчийн загвараар үйл ажиллагаа явуулж эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн байгууллагуудын төлбөр тооцоог төвлөрсөн байдлаар зохицуулдаг бөгөөд тухайн худалдан авагчаас бодитоор орж ирсэн төлбөрийн хэмжээнээс хамааран мөнгөн урсгал хуваарилагддаг онцлогтой байна. Үүний үр дүнд компанийн санхүүгийн тайланд нэг худалдан авагчтай холбоотой 13,256.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

БНХАУ-ын "Өвөр Монголын Эрчим хүчний олон улсын хамтын ажиллагааны компани" болон "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн хооронд 2017 онд байгуулсан "Монголын Оюутолгой төсөлд зориулж цахилгаан эрчим хүч худалдан авах, худалдах тухай гэрээ"-ний дагуу цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах үйл ажиллагаанаас үүссэн орлогыг борлуулалтын орлогоор, түүнтэй холбоотой зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртгөөр хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд тусгаж байгаа нь тухайн компанийн борлуулалтын орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийг их хэмжээгээр өсгөж байна.

Бусад асуудлын хэсэг

Дамжуулах сүлжээний нэгдсэн систем үүсгэгч 220/110 кВ-ын 13 дэд станцад диспетчерийн хяналт, удирдлагын систем /SCADA-ийг нэвтрүүлснээр эрчим хүчний системийн баланс сайжирч, зүй бус алдагдал эрс багасаж, мэдээллийг түргэн шуурхай авах шинэ технологи бүхий диспетчерийн хяналт мэдээллийн систем бий болжээ. Хуучирсан тоноглолуудыг шинэчилснээр ашиглалтын ажиллагаа сайжирч, тасралт, гэмтлийн тоо буурч, эрчим хүчийг үр ашигтай, найдвартай дамжуулах нөхцөл бололцоо бүрдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,545,319,186.01	3,382,695,810.13
1.1.2	Дансны авлага	6,002,968,179.66	13,256,846,653.80
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	310,884,997.37	7,438,465.85
1.1.4	Бусад авлага	1,403,822,095.20	4,556,819,117.02
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	8,696,802,168.52	9,834,621,815.24
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,615,453,134.96	236,919,316.29
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	22,575,249,761.72	31,275,341,178.33
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	498,446,569,838.63	527,608,382,352.67
1.2.2	Биет бус хөрөнгө	62,416,990,427.96	62,978,807,833.79
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	628,344,141.36	575,982,129.58
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	273,979,080,441.15	308,055,752,268.75
1.2.9		-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	835,470,984,849.10	899,218,724,584.79
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	858,046,234,610.82	930,494,065,763.12
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3	Татварын өр	-	126,331,543.38
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	3,905,481.48
2.1.1.5	Богино хугацаат зээл	8,167,000,043.50	2,667,000,042.76
2.1.1.6	Хүүний өглөг	15,239,367.87	14,824,793.43
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	772,869,961.35	657,099,635.01
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) -нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,955,109,372.72	3,469,161,496.06
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	279,590,106,525.71	339,852,336,303.68
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,343,818,779.47	1,270,154,290.44
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	252,206,141,008.83	242,338,300,735.52
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	533,140,066,314.01	583,460,791,329.64
2.2	Өр төлбөрийн нийт дүн	542,095,175,686.73	586,929,952,825.70
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	238,073,068,351.04	238,073,068,351.04
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	45,946,677,439.64	45,731,293,511.91
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	61,087,415,220.00	105,831,805,222.64
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(29,156,102,086.59)	(46,072,054,148.17)
2.3.11	Эздийн өмчийн дүн	315,951,058,924.09	343,564,112,937.42
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	858,046,234,610.82	930,494,065,763.12

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	528,239,341,671.79	634,412,793,073.52
2	Борлуулалтын өртөг	533,404,568,391.15	618,637,368,043.79
3	Нийт ашиг (алдагдал)	(5,165,226,719.36)	15,775,425,029.73
4	Түрээсийн орлого	30,520,000.10	40,365,454.60
5	Хүүний орлого	36,908,730.08	33,882,975.32
8	Бусад орлого	26,462,691,594.09	32,674,074,559.45
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	13,601,189,878.14	13,925,572,157.04
11	Санхүүгийн зардал	2,876,623,356.36	18,338,939,024.15
12	Бусад зардал	5,799,642,675.55	21,176,608,628.46
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(866,979,340.62)	(12,109,136,489.52)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(454,710,567.26)	(104,716,774.21)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,234,252,213.02)	(17,131,225,054.28)
19	Орлогын татварын зардал	3,792,463.66	4,987,974.15
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,238,044,676.68)	(17,136,213,028.43)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,238,044,676.68)	(17,136,213,028.43)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	144,573,940,653.44	216,561,104,561.21
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	70,904,544,291.07	119,931,911,694.87
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	155,906,312.00	199,696,516.00
	Бусад мөнгөн орлого	73,513,490,050.37	96,429,496,350.34
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	141,984,629,329.41	206,604,297,997.62
	Ажиллагчдад төлсөн	36,312,908,462.54	58,371,192,621.07
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	11,614,969,063.04	17,875,664,155.51
	Бараа материал худалдан авахад төлсөн	6,073,272,126.59	17,374,158,847.95
	Ашиглалтын зардалд төлсөн	402,195,018.19	474,283,840.75
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,217,513,591.60	2,308,256,741.65
	Хүүний төлбөрт төлсөн	95,450,987.38	13,022,162.22
	Татварын байгууллагад төлсөн	77,666,383,804.67	94,692,039,735.40
	Даатгалын төлбөрт төлсөн	55,819,274.44	87,496,198.48
	Бусад мөнгөн зарлага	7,546,117,000.96	15,408,183,694.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,589,311,324.03	9,956,806,563.59



**“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	85,892,798.03	76,226,173.02
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	55,422,548.54	42,343,197.70
	Хүлээн авсан хүүний орлого	30,470,249.49	33,882,975.32
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,086,244,801.49	3,382,043,880.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,079,314,801.49	3,382,043,880.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,930,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,000,352,003.46)	(3,305,817,706.98)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,056,522.74	24,871,977.10
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	11,807,869.16	23,054,549.58
	Бусад	1,248,653.58	1,817,427.52
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	274,634,963.48	5,838,484,209.59
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	271,453,867.51	5,838,072,755.70
	Бусад	3,181,095.97	411,453.89
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(261,578,440.74)	(5,813,612,232.49)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,246,513,189.91)	837,376,624.12
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,791,832,375.92	2,545,319,186.01
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,545,319,186.01	3,382,695,810.13

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	/төгрөгөөр/		
				Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	238,073,068,351.04	45,985,469,154.04	33,667,158,220.00	(26,907,770,396.34)	290,817,925,328.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(10,287,013.57)	(10,287,013.57)
3	Залруулсан үлдэгдэл	238,073,068,351.04	45,985,469,154.04	33,667,158,220.00	(26,918,057,409.91)	290,807,638,315.17
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,238,044,676.68)	(2,238,044,676.68)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт			27,420,257,000.00		27,420,257,000.00
7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(38,791,714.40)			(38,791,714.40)
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	238,073,068,351.04	45,946,677,439.64	61,087,415,220.00	(29,156,102,086.59)	315,951,058,924.09
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-		220,260,966.85	220,260,966.85
11	Залруулсан үлдэгдэл	238,073,068,351.04	45,946,677,439.64	61,087,415,220.00	(28,935,841,119.74)	316,171,319,890.94
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(17,136,213,028.43)	(17,136,213,028.43)
14	Өмчид гарсан өөрчлөлт			44,744,390,002.64		44,744,390,002.64
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(215,383,927.73)			(215,383,927.73)
17	2025 оны 06-р сары 30-ний үлдэгдэл	238,073,068,351.04	45,731,293,511.91	105,831,805,222.64	(46,072,054,148.17)	343,564,112,937.42



2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2025 оны		Хэлбэлзэл	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Дамжуулах цахилгаан эрчим хүч		сая.кВт.ц	8,765.9	8,935.6	169.8	101.9
	Дамжуулалтын алдагдал	хувиар	хувь	3.54	3.52	(0.02)	99.4
		биетээр	сая.кВт.ц	310.5	314.6	4.1	101.3
	Дамжуулсан цахилгаан эрчим хүч		сая.кВт.ц	8,455.3	8,621.0	165.7	102.0
2	Нийт орлого		сая.төг	670,875.4	671,037.4	162.0	100.0
	Үүнээс:	Үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төг	119,454.4	119,454.4	-	100.0
		Оюутолгой ХХК гэрээний орлого	сая.төг	514,958.4	514,958.4	(0.0)	100.0
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого		сая.төг	36,462.6	36,624.6	162.0	100.4
3	Нийт зардал		сая.төг	689,558.3	688,168.6	(1,389.7)	99.8
	Үүнээс:	Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төг	135,235.2	135,943.5	708.3	100.5
		Оюутолгой ХХК гэрээний зардал	сая.төг	514,958.4	514,958.4	(0.0)	100.0
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал		сая.төг	39,364.7	37,266.7	(2,097.9)	94.7
	Элэгдэл		сая.төг	28,708.3	28,464.3	(244.0)	99.2
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая.төг	(18,682.9)	(17,131.2)	1,551.7	91.7
	Орлогын татварын зардал		сая.төг	0.0	5.0	5.0	
5	Цэвэр ашиг алдагдал		сая.төг	(18,682.9)	(17,136.2)	1,546.7	91.7
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал		төг	1.03	1.03	(0.0)	99.8
7	Нийт авлага		сая.төг	2,655.2	18,397.1	15,741.9	692.9
	Үүнээс:	ЦЭХ	сая.төг	1,751.6	13,256.8	11,505.2	756.8
		Бусад	сая.төг	327.7	4,564.3	4,236.6	1393.0
		Урт хугацаат авлага	сая.төг	576.0	576.0	0.0	100.0
8	Нийт өглөг		сая.төг	671,931.0	586,930.0	(85,001.1)	87.3
	Үүнээс:	Богино хугацаат өглөг	сая.төг	26,510.6	3,469.2	(23,041.5)	13.1
		Урт хугацаат өглөг	сая.төг	645,420.4	583,460.8	61,959.6)	90.4
9	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая.төг	26,909.0	12,572.9	(14,336.1)	46.7
10	Нийт ажилтны тоо		хүн	1,561	1,444	(117.0)	92.5
11	Цалингийн сан		сая.төг	65,856.5	65,761.5	(95.0)	99.9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн эрхэм зорилгыг "Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан цахилгаан эрчим хүчийг үр ашигтай дамжуулна" гэж тодорхойлсон байна.

Тус компанийн дүрэмд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Цахилгаан эрчим хүч дамжуулах;
- 0.4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил гүйцэтгэх;
- Цахилгаан эрчим хүч импортлох;
- Мэргэжлийн сургалт явуулах;
- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах.

"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК 10 хэлтэс, 1 төсөл хэрэгжүүлэх нэгж, Улаанбаатар болон Хангай, Төв, Зүүн өмнөд, Говь, Алтай-Улиастай, Баруун бүсийн орон нутгийн 7 салбарын хүрээнд 1356 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд Эрчим хүчний яам 66.0 хувь, "Эрчист Монгол" ТӨХХК 34.0 хувийг эзэмшиж байна.

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2, Эрчим хүчний яам 4, хараат бус 3, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК үндсэн үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомжийг мөрдөж байна. Үүнд,

- Эрчим хүчний тухай
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай
- Сэргээгдэх эрчим хүчний тухай
- Компанийн тухай

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн Хяналт мониторингийн хэлтсийн 2025 оны төлөвлөгөө, түүний биелэлтийн тайлангаар нийт 43 ажил төлөвлөснөөс санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 4 ажлын биелэлт хангалттай байна.

"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий болон ахлах нягтлан бодогч нар нь бусад төв удирдлагын болон салбарын санхүүгийн ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

**“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрчим хүчний салбарын хэмжээнд мөрдөх 2016 оны бүртгэлийн бодлогын баримт бичигт үндэслэн 2018 онд боловсруулсан “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байгаа боловч тус баримт бичигт холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын шинэчлэл тусгагдаагүй, компанийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Компанийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 930,494.1 сая төгрөг болж өмнөх оноос 72,447.8 сая төгрөгөөр буюу ойролцоогоор 8.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,545,319.2	3,382,695.8	837,376.6
Дансны авлага	7,717,675.3	17,821,104.2	10,103,428.9
Бараа материал	8,696,802.2	9,834,621.8	1,137,819.6
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,615,453.1	236,919.3	(3,378,533.8)
Үндсэн хөрөнгө	498,446,569.8	527,608,382.4	29,161,812.5
Биет бус хөрөнгө	62,416,990.4	62,978,607.8	561,617.4
Урт хугацаат хөрөнгө оруулалт	628,344.1	575,982.1	(52,362.0)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	273,979,080.4	308,055,752.3	34,076,671.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	858,046,234.6	930,494,065.8	72,447,831.2
Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,955,109.4	3,469,161.5	(5,485,947.9)
Урт хугацаат өр төлбөрийн дүн	533,140,066.3	583,460,791.3	50,320,725.0
Өмч: - төрийн	238,073,068.4	238,073,068.4	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	45,946,677.4	45,731,293.5	(215,383.9)
Эздийн өмчийн бусад хэсэг	61,087,415.2	105,831,805.2	44,744,390.0
Хуримтлагдсан ашиг	(29,156,102.1)	(46,072,054.1)	(16,915,952.1)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	858,046,234.6	930,494,065.8	72,447,831.2

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансдын үзүүлэлтүүд нөлөө бүхий дүнгээр өөрчлөгдсөн байна. Үүнд:

- Дансны авлагын 74.2 хувь буюу 13,256.8 сая төгрөг нь нэг худалдан авагчийн үүрэг гүйцэтгэгч "Диспетчерийн үндэсний төв" ТӨХК-иас авах авлага байна;
- Үндсэн хөрөнгө дансны өсөлт нь ТӨБЗГ-ын 2025 оны 604, 605 дугаар тогтоолын дагуу "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК, "Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 599 нэр төрлийн 55,778.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж авсантай холбоотой байна;
- Бусад эргэлтийн бус хөрөнгө дансны үлдэгдэлд тайлагнасан 280,416.1 сая төгрөг нь "Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл" OL-3874-MN-ийн ашиглалт тайлант онд 21,201.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна;
- Урт хугацаат өр төлбөрт Эрчим хүчний яамны дамжуулан зээлээр хэрэгжиж буй төслүүдийн зээлийн үлдэгдэл бүртгэлтэй байгаагаас тухайлбал, "УБЦТС" ТӨХК-иас "Эрчим хүчний төсөл" 4673MN төсөл, "УБДС" ТӨХК-иас "Эрчим хүчний хэмнэлт" 1492MON(SF) төслийн өр төлбөрийн үлдэгдэл зэргийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна;
- Эздийн өмчийн бусад хэсэгт 92 газарт шинээр, хэмжээ өөрчлөгдсөн 8 газарт үнэлгээ хийлгэж бүртгэлд тусгасан ба ТӨБЗГ-ын 604, 605 дугаар тогтоолуудын дагуу дэд станцын газрууд балансаас балансад шилжиж ирснийг бүртгэсэн байна.

3.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/10 дугаар тушаалаар компанийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Түүнээс хойш А/162, А/239 болон А/367 дугаар тушаалуудаар нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн баталжээ.

Тайлант оны нийт орлогыг 670,875.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 689,558.3 сая төгрөгөөр буюу 18,682.8 сая төгрөгийн алдагдалтай төлөвлөгөө баталсан байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 34,909.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна.



**“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

Хүснэгт 2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний 2025 оны төлөвлөгөө, түүний тодотгол

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 оны тушаалын дугаар				Хэлбэлзэл	
			A/10	A/162	A/239	A/367		
			Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө		
1	Дамжуулах цахилгаан эрчим хүч	сая.кВт.ц	9,011.8	8,765.9	8,765.9	8,765.9	(245.9)	
	Дамжуулалтын алдагдал	хувиар	3.7	3.5	3.5	3.5	(0.2)	
		биетээр	сая.кВт.ц	325.4	310.5	310.5	310.5	(14.9)
	Дамжуулсан цахилгаан эрчим хүч	сая.кВт.ц	8,509.6	8,455.3	8,455.3	8,455.3	(54.3)	
Нийт орлого			сая.төг	618,817.2	636,468.7	636,468.7	670,875.4	52,058.2
2	Үүнээс:	Үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төг	124,288.4	119,454.4	119,454.4	119,454.4	(4,834.0)
		Оюутолгой ХХК гэрээний орлого	сая.төг	481,628.7	481,628.7	481,628.7	514,958.4	33,329.7
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	12,900.1	35,385.6	35,385.6	36,462.6	23,562.5	
Нийт зардал			сая.төг	613,927.8	629,111.5	629,111.5	689,558.3	75,630.5
3	Үндсэн үйл ажиллагааны зардал		сая.төг	612,097.0	605,224.7	605,224.7	650,193.6	38,096.6
	Үүнээс:	Элэгдэл	сая.төг	28,708.3	28,708.3	28,708.3	28,708.3	0.0
		Оюутолгой ХХК гэрээний зардал	сая.төг	481,628.7	481,628.7	481,628.7	514,958.4	33,329.7
		Бусад тогтмол	сая.төг	101,760.0	94,887.7	94,887.7	106,526.9	4,766.9
		Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	1,830.8	23,886.8	23,886.8	39,364.7	37,533.9
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая.төг	4,889.4	7,357.2	7,357.2	(18,682.9)	(23,572.3)
	Орлогын татварын зардал		сая.төг	488.9	-	-	-	(488.9)
5	Цэвэр ашиг алдагдал		сая.төг	4,400.5	7,357.2	7,357.2	(18,682.9)	(23,083.4)
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал		төг	0.99	0.99	0.99	0.99	-
7	Нийт авлага		сая.төг	1,751.6	2,655.2	2,655.2	2,655.2	903.6
	Үүнээс:	ЦЭХ	сая.төг	1,751.6	1,751.6	1,751.6	1,751.6	-
		Бусад	сая.төг		903.6	903.6	903.6	903.6
		Урт хугацаат авлага	сая.төг					-
Нийт өглөг			сая.төг	553,043.0	671,931.0	671,931.0	671,931.0	118,888.0
8	Үүнээс:	Богино хугацаат өглөг	сая.төг	11,173.0	26,510.6	26,510.6	26,510.6	15,337.6
		Урт хугацаат өглөг	сая.төг	541,870.0	645,420.4	645,420.4	645,420.4	103,550.4
9	Нийт ажилтны тоо		хүн	1,364.0	1,356.0	1,356.0	1,561.0	197.0
10	Цалингийн сан		сая.төг	71,709.2	65,727.6	65,727.6	65,856.5	(5,852.7)
11	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая.төг	34,909.9	34,910.3	34,909.9	34,909.9	-
	Санхүүжих	2025 он	сая.төг	26,909.0	26,909.0	26,909.0	26,909.0	-
		2026 он	сая.төг	8,000.9	8,001.3	8,000.9	8,000.9	-

Дээрх хүснэгтээс үзэхэд 2025 оны зорилтот түвшний төлөвлөгөөг дахин тодотгож батлахдаа орлогыг анх баталснаас 52,058.2 сая төгрөг, зардлыг 78,630.5 сая төгрөгөөр нэмсэн байна. Үүнээс шалтгаалан тайлант үеийн алдагдал анх баталснаас 23,083.4 сая төгрөгөөр нэмэгдэж, мөн авлага, өр төлбөрийн дүн нэмэгдсэн байна.

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 671,037.4 сая төгрөгийн орлоготой, 688,168.6 сая төгрөгийн зардалтай буюу 17,131.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого төлөвлөснөөс 162.0 сая төгрөгөөр илүү буюу 100 хувийн, нийт зардал төлөвлөснөөс 1,389.7 сая төгрөгийн дутуу буюу 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд нийт 26,909.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 12,572.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Хүснэгт 3. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний 2024 ба 2025 оны гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хэлбэлзэл Дүн	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Дамжуулах цахилгаан эрчим хүч	сая кВт.ц	8,310.0	8,330.1	8,765.9	8,935.6	605.5	
	Дамжуулалтын алдагдал	хувиар	3.7	3.7	3.5	3.5	(0.1)	
		биетээр	сая кВт.ц	307.0	305.4	310.5	314.6	9.2
	Сонгино хуримтлуур	сая кВт.ц	83.4	76.5			(76.5)	
Дамжуулсан цахилгаан эрчим хүч	сая кВт.ц	7,919.7	8,024.8	8,455.3	8,621.0	596.3		
2	Нийт орлого	сая.төг	550,740.0	557,152.2	670,875.4	671,037.4	113,885.2	
	Үүнээс:	Үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төг	74,120.7	85,345.5	119,454.4	119,454.4	34,108.9
		Оюутолгой ХХК гэрээний орлого	сая.төг	458,328.8	442,893.9	514,958.4	514,958.4	72,064.5
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	18,290.5	28,912.9	36,462.6	36,624.6	7,711.7	
3	Нийт зардал	сая.төг	569,797.0	559,386.5	689,558.3	688,168.6	128,782.1	
	Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төг	564,299.8	549,882.4	650,193.6	650,901.9	101,019.5	
	Үүнээс:	Элэгдэл	сая.төг	26,653.8	28,330.6	28,708.3	28,464.3	133.6
		Оюутолгой ХХК гэрээний зардал	сая.төг	458,328.8	442,893.9	514,958.4	514,958.4	72,064.5
Бусад тогтмол	сая.төг	79,317.1	78,657.9	106,526.9	107,479.2	28,821.3		
4	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	5,487.2	9,504.1	39,364.7	37,266.7	27,762.7	
	Татварын өмнөх ашиг (алдагдал)	сая.төг	-19,057.0	(2,234.3)	(18,682.9)	(17,131.2)	(14,897.0)	
5	Орлогын татварын зардал	сая.төг	0.0	3.8	0.0	5.0	1.2	
	Цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	-19,057.0	(2,238.1)	(18,682.9)	(17,136.2)	(14,898.1)	
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	1.0	1.0	0.0	
7	Нийт авлага	сая.төг	3,163.1	8,346.0	2,655.2	18,397.1	10,051.1	
	Үүнээс:	ЦЭХ	сая.төг	2,402.2	6,003.0	1,751.6	13,256.8	7,253.9
		Бусад	сая.төг	132.6	1,714.7	327.7	4,564.3	2,849.6
	Урт хугацаат авлага	сая.төг	628.3	628.3	576.0	576.0	(52.4)	
8	Нийт өглөг	сая.төг	514,925.3	542,095.2	671,931.0	586,930.0	44,834.8	
	Үүнээс:	Богино хугацаат өглөг	сая.төг	20,008.5	8,955.1	26,510.6	3,469.2	(5,485.9)
		Урт хугацаат өглөг	сая.төг	494,916.8	533,140.1	645,420.4	583,460.8	50,320.7
9	Их засвар, ТЗБАХ Хөрөнгө оруулалт	сая.төг	19,031.5	16,153.9	26,909.0	12,572.9	(3,581.0)	
10	Нийт ажилтны тоо	хүн	1,305.0	1,299.0	1,561.0	1,444.0	145.0	
11	Цалингийн сан	сая.төг	56,105.5	55,920.8	65,856.5	65,761.5	9,840.6	

Өмнөх онтой харьцуулахад, тайлант онд дамжуулсан цахилгаан эрчим хүч 596.3 сая кВт.ц-аар, мөн нийт орлого, зарлага нэмэгдсэнээс алдагдал 14,898.1 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Бүтэц орон тоо: Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 30-р тогтоолоор Баруун бүсийн ЦЭХ-ний найдвартай байдлыг хангах зорилгоор “ББЭХС” ТӨХК, “АУЭХС” ТӨХК-ийг “ЦДҮС” ТӨХК-д нэгтгэхээр шийдвэрлэсний дагуу салбарын тоо 2, орон тоог 205-аар нэмж 1561 хүнээр баталснаас тайлант оны гүйцэтгэлээр 1444 орон тоотой ажиллажээ.

Мэдээллийн технологи, биет бус хөрөнгө: Судалгаагаар тус компанийн хэмжээнд нийт 3,660.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий 94 нэрийн лиценз, програм хангамжийг биет бус хөрөнгөөр бүртгэн үндсэн үйл ажиллагаа, технологи, санхүү, бичиг хэрэг, архив, цайны газар зэрэг чиглэлээр ашиглаж байна. Тайлант онд хөгжүүлэлттэй холбоотой урсгал зардалд 395.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 47.6 сая төгрөг, нийт 442.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Гадаад томилолт: Эрчим хүчний шуурхай ажиллагаа, горим тооцоо, реле хамгаалалт, хэмжилтийн туршлага судлах, хамтарсан хяналт хэмжилт хийх, тооцооны тоолуур солих, засаглал, удирдлага, тарифын аргачлал, сэргээгдэх эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх системийн тогтворжилтыг хангах сургалтад хамруулах зорилгоор 103.1 сая төгрөгийг зарцуулсан байна.



**“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэлийг орлого зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар баталсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг А/123 дугаар тушаалаар шинэчилж, А/220 дугаар тушаалаар нэмэлт төлөвлөгөө баталсан байна.

Нэмэлт өөрчлөлтөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний үнийн дүн 2,559.7 сая төгрөгөөр өсөж, 28,088.5 сая төгрөгөөр батлагджээ.

Хүснэгт 4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тодотгол, түүний гүйцэтгэл

Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө Төсөвт өртөг /мян.төг/			НИЙТ	Гэрээний гүйцэтгэлийн болон худалдан авалтын дүн	Хэмнэлт
	2025.01.09 А/04	2025.07.01 А/123	2025.12.25 А/220			
1	2	3	4	5=3+4	6	7=6-5
ИХ ЗАСВАР	985,836.5	1,105,198.3	239,711.4	1,344,909.7	1,179,159.4	(165,750.3)
1.Барилгын засварын чиглэлээр	829,924.3	912,850.4	117,105.2	1,029,955.6	987,171.9	(42,783.7)
2.Автомашин механизмын засварын чиглэлээр	155,912.2	192,347.9	87,106.2	279,454.1	173,960.2	(105,493.9)
1.3 Автомашин механизмын засварын чиглэлээр			35,500.0	35,500.0	18,027.3	(17,472.7)
ТЕХНИК ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ	5,895,805.0	5,228,294.9	2,361,560.1	7,589,855.1	5,482,915.6	(2,106,939.5)
1.Шугам тоноглолын чиглэлээр	3,945,005.2	3,542,549.0	397,936.4	3,940,485.4	3,690,570.5	(249,914.9)
2.Реле хамгаалалтын чиглэлээр	364,834.2	347,583.4		347,583.4	317,766.3	(29,817.1)
3.Мэдээлэл технологи, холбооны чиглэлээр	614,400.0	380,390.0	224,139.7	604,529.7	539,952.2	(64,577.5)
4.Барилгын чиглэлээр	971,565.6	957,772.6	1,739,484.0	2,697,256.5	934,626.6	(1,762,629.9)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4,654,881.5	4,851,881.5	622,308.0	5,474,189.6	3,262,969.6	(2,211,220.0)
1.Багаж хэрэгслийн чиглэлээр	1,345,381.5	1,328,501.5		1,328,501.5	1,167,800.0	(160,701.5)
2.Компьютер, цахилгаан бараа, мэдээллийн технологийн чиглэлээр	99,500.0	487,311.1	80,000.0	567,311.1	529,669.6	(37,641.5)
3.Тавилга хэрэгслийн чиглэлээр		60,000.0	92,308.0	152,308.0	132,350.0	(19,958.0)
4.Машин механизмын чиглэлээр	3,210,000.0	2,976,068.9	450,000.0	3,426,068.9	1,433,150.0	(1,992,918.9)
ИХ ЗАСВАРЫН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ СЭЛБЭГ МАТЕРИАЛ	2,458,747.2	2,399,085.8		2,399,085.8	2,106,615.5	(292,470.3)
ХАБЭА, ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ ХУДАЛДАН АВАЛТ	1,287,916.1	1,100,074.3	48,615.7	1,148,690.0	988,116.3	(160,573.7)
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ ХУДАЛДАН АВАЛТ	1,888,722.2	1,739,936.6	35,000.0	1,774,936.6	1,642,877.3	(132,059.3)
БОГД ДЭД СТАНЦ БАРИХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД	8,356,800.0	8,356,800.0		8,356,800.0	7,767,157.0	(589,643.0)
ЕРӨНХИЙ ДҮН, мянаан төгрөг	25,528,708.5	24,781,271.4	3,307,195.3	28,088,466.7	22,429,810.7	(5,658,656.0)

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө 5,658.7 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан байна. Энэ нь техник, зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан барилгын чиглэлээрх худалдан авалт болон машин механизмын хөрөнгө оруулалт болох "Крантай ачааны машин/краны даац 8-10 тонн/", "Гинжит экскаватор Develon DX530LC түүнтэй дүйцэхүйц"-ийн нийлүүлэгч шалгаруулах тендер он дамжсан, мөн 110/1 кВ-ийн Богд дэд станцын барилга барих гүйцэтгэчийг шалгаруулах тендерийг зарласан боловч оролцогчгүйгээс ахин зарласан зэргээс шалтгаалсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудитад хамрагдсан компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилтот түвшний төлөвлөгөө, өртгийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Ворлдвайд файнэнс Аудит" ХХК-ийн ахлах аудитор Д.Уламбаяр, аудитор Ж.Болормаа, Д.Энхбаяр нар гүйцэтгэж, захирал С.Оюунгэрэл анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор С.Отгонхорлоо, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/258 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 554,769.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,547.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зорилт нь төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төлөвлөлтийн үе шатанд энэхүү хуульд заасан 72 шалгуур үзүүлэлтээс тус байгууллагад хамааралтай шалгуур үзүүлэлтийг сонгож горим сорил хэрэгжүүлсэн ба хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг



**“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, бусад гэсэн дэд цэсүүдэд байршуулбал зохих мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, нийт 89,583.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж хүргүүлсний дагуу санхүүгийн тайланд 38,363.0 сая төгрөгийн залруулгыг бүрэн хийсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг Гүйцэтгэх захирлын 2025 оны 01/938 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Дундманхайдай аудит ХХК гүйцэтгэж, нийт 66,518.1 сая төгрөгийн алдаа зөрчилд өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянаж, үнэлэхэд хэрэгжилт 85.0 хувьтай байна.

Ажилчдын илүү цагийн нэмэгдэл цалинг зөрүүтэй олгосон, үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа уул уурхайн хүнд даацын болон үйлчилгээний автомашины шатахуун зарцуулалтыг нормоос илүү тооцож олгосон зөрчилд тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна.

Хүснэгт 6. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	16,992.4	2	16,992.4	100%
Албан шаардлага	8	1,580,390.3	8	1,580,390.3	72.6%
Албан шаардлага (шилэн данс)	1	901,689.2	1	901,689.2	80.8%
Зөвлөмж	4	2,136,900.0	4	2,136,900.0	86.6%
Нийт дүн	15	4,635,971.9	15	4,635,971.9	85.0%

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчилд хүргүүлсэн албан шаардлагын 92.0 хувь буюу 1,448.1 сая төгрөг нь бараа материалын нөөц үүсгэсэн, төлөвлөснөөс илүү шатахуун худалдан авсан болон шууд худалдан авалт хийсэн зэрэг зөрчил байсан ба тайлант онд давтан гараагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Компанийн үйл ажиллагаа өргөжиж нийт 7 салбартай болсонтой холбоотой шинээр нэмэгдсэн салбаруудын хөрөнгийн бүртгэл, санхүүгийн тайлангийн нэгтгэлийн үйл явцыг нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 38,363.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Тайлант хугацааны нэгтгэсэн гүйлгээ балансад машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй түгээгүүр, ачиж буулгах төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдэл 3.6 сая төгрөгийг хайгуул үнэлгээний хөрөнгийн бүлэгт тайлагнасан;
- Байгууллагын эзэмшилд байгаа 38,359.4 сая төгрөгийн газар эзэмших эрхийн гэрчилгээг биет бус хөрөнгөөр бүртгэсэн боловч салбар нэгж тус бүр өөр өөр дансанд, тухайлбал, бусад биет бус хөрөнгө, зохиогчийн эрх зэрэг дансанд бүртгэсэн зэрэг нь НББОУС 1 Санхүүгийн тайлагчийн толилуулгын 15-д "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой.", Толилуулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 182.5 сая төгрөгийн зөрчил² илрүүлж, 99.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 82.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 зөвлөмж өглөө.

Нийт залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс даваагүй тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой зөв ойлголтыг олон нийтэд сурталчлах зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр нэр бүхий 5 компанитай шууд гэрээ байгуулж, нийт 99.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "..., төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4-т "... бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, ... зэргийг санхүүжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:


1. Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжсэн Компанийн захиргаа, ҮЭХ-той байгуулсан 2023-2024 оны Хамтын гэрээний 2.18-д "ТЗТБ-аас ТА цол тэмдгээр шагнагдсан ажилтанд 2023 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс 15.000 төгрөг олгоно /Энэ заалт ахмад настан болон группэд байгаа хүмүүст нэгэн адил хамаарагдана/" гэснийг үндэслэн 2025 оны 3 дугаар улирлын дүнгээр зөвхөн төв удирдлагын хэмжээнд нийт 8.2 сая төгрөг зарцуулжээ. 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн 2025-2026 оны Хамтын гэрээний 2.17-д тухайн шагналыг "сар бүр олгоно" гэж заасан байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "... шагнал олгох журам"-ын 1.5-д "Шагналыг байгууллагын, Засгийн газрын, төрийн дээд шагнал гэсэн дарааллаар олгоно. ... тухайн ажилтны ажлын үр дүн өмнөх түвшингээс ахисан, сахилгын болон ёс зүйн зөрчилгүй, ... өмнөх шагналаас хойш 3-аас доошгүй жил

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



**“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

ажиллаж байгаа бол дараагийн шатны шагналыг олгох зарчим баримтална” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэг удаагийн шинж чанартай шагналын дагалдах мөнгийг тогтмол олгодог асуудлыг шийдвэрлэх, хамтын гэрээнд өөрчлөлт оруулах.

2. Төрд учруулсан хохирлын талаар

Илрүүлэлт: Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн Гүйцэтгэх захиралд ХУД-ийн ИХАШШ-ийн 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 183/ШШ2023/03201 дүгээр шийдвэр, 2024 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 183/ГХ2024/01260 дугаар гүйцэтгэх хуудсаар 74.5 сая төгрөгийг олгож, ЭХЯ-аас авах авлагаар бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шүүхийн шийдвэртэй холбоотой авлагын эзэн холбогдогчийг тодорхой болгох, барагдуулах талаар арга хэмжээ авах, холбогдох авлагыг барагдуулах

3. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Компанийн техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг ЭХС-ын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталснаас хойш 3 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд үйл ажиллагааны үр дүнг анх батлагдсан төлөвлөгөөнд 4.400.5 сая төгрөгийн ашигтайгаар баталсан бол 3 дахь өөрчлөлтөөр 18,682.9 сая төгрөгийн алдагдалтай байхаар баталжээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1-д “Захирал дараах эрх үүрэгтэй”, 1.3-т “... Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, биелэлтийг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг бодитой төлөвлөх, алдагдалтай төсөв батлуулахгүй байх

4. Өртгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцох талаар тодорхой бодлого тусгаагүй, байгууллагын бүтцээр ерөнхий инженерийн удирдлагад байгаа газар хэлтсийн зардлыг өртөгт хуримтлуулан бүртгэдэг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцох аргачлалыг нэмэлт зардал гаргахгүйгээр өөрсдийн нөөц боломжоор боловсруулж батлан мөрдөх, өртгийн обектыг тодорхой болгож, үнэн зөв тодорхойлох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Үүнээс		Залруулаагүй		Тоо	Дүн
							Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн		
Тайлант хугацааны нэгтгэсэн гүйлгээ балансад машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй түгээгүүр, ачиж буулгах төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдэл 3.6 сая төгрөгийг хайгуул үнэлгээний хөрөнгийн бүлэгт тайлагнасан,	1	3,632.4			1	3,632.4	1	3,632.4				
Байгууллагын эзэмшилд байгаа 38,359.4 сая төгрөгийн газар эзэмших эрхийн гэрчилгээг биет бус хөрөнгөөр бүртгэсэн боловч салбар нэгж тус бүр өөр өөр дансанд, тухайлбал, бусад биет бус хөрөнгө, зохиогчийн эрх зэрэг дансанд бүртгэсэн	1	38,359,375.4			1	38,359,375.4	1	38,359,375.4				
Дүн	2	38,363,007.8			2	38,363,007.8	2	38,363,007.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой зөв ойлголтыг олон нийтэд сурталчлах зорилгоор 2025.02.12-ны өдөр нэр бүхий 5 компанид тус бүр 19.9 сая төгрөг, нийт 99.8 сая төгрөгийн шууд гэрээ байгуулан зарцуулсан байна.	1	99,800.0			1	99,800.0						
2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжсэн Компанийн захиргаа, ҮЭХ-ны хооронд байгуулсан 2023-2024 оны Хамтын гэрээний												



**“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн
2025 оны санхүүгийн тайлангийн аудит**

2.18-д "ТЗТБ-аас ТА цол тэмдгээр шагнагдсан ажилтанд 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 15.000 төгрөг олгоно /Энэ заалт ахмад настан болон группэд байгаа хүмүүст нэгэн адил хамаарагдана/" гэснийг үндэслэн 2025 оны 3 дугаар улирлын дүнгээр зөвхөн ТУ-ын хэмжээнд нийт 8.2 сая төгрөг зарцуулжээ. 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн 2025-2026 оны Хамтын гэрээний 2.17-д тухайн шагналыг "сар бүр олгоно" гэж заасан байна.	1	8,160.0					1	8,160.0				
Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн гүйцэтгэх захиралд ХУД-ийн ИХАШШ-ийн 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 183/ШШ2023/03201 дүгээр шийдвэр, 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 183/ГХ2024/01260 дугаар гүйцэтгэх хуудсаар 74.5 сая төгрөгийг олгож, ЭХЯ-аас авлагаар бүртгэсэн байна.	1	74,514.7					1	74,514.7				
Компанийн техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг ЭХС-ын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталснаас хойш 3 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд үйл ажиллагааны үр дүнг анх батлагдсан төлөвлөгөөн 4.400.5 сая төгрөгийн ашигтайгаар баталсан бол 3 дахь өөрчлөлтөөр 18,682.9 сая төгрөгийн алдагдалтай байхаар баталжээ.	1						1					
Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцох талаар тодорхой бодлого тусгаагүй, байгууллагын бүтцээр ерөнхий инженерийн удирдлагад байгаа газар хэлтсийн зардлыг өртөгт хуримтлуулан бүртгэдэг байна.	1						1					
НИЙТ ДҮН	6	182,474.7				1	99,800.0	5	82,674.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 710/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/84/КА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой зөв ойлголтыг олон нийтэд сурталчлах зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр нэр бүхий 5 компанитай шууд гэрээ байгуулж, нийт 99,800,000.00 /Ерэн есөн сая найман зуун мянган/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "... төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4-т "... бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, ... зэргийг санхүүжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж ... зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Дашдаваа), Ерөнхий нягтлан бодогч (Э.Болор-Эрдэнэ) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ВОРЛДВАЙД ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН

С.ОЮУНГЭРЭЛ

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр

Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг